



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Үндэсний дата төв УТҮГ-аас төрийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний дата төв УТҮГ-ын захирал /Д.Энхцог/-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Журам батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагад домэйн нэрийг олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох журам”-ыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЖАДАМБАА

**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТҮГ-ААС ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГАД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Тус журам нь Төрийн захиргааны төв байгууллага – яам, агентлаг, Төрийн захиргааны байгууллага, түүний харъяа байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, бүх шатны засаг даргын тамгын газар, бусад төрийн байгууллагад үйлчилгээ үзүүлэх, өөрчлөлт оруулах, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус журмаар дараах үйлчилгээг үзүүлнэ.

Нэг. Домэйн нэрийн үйлчилгээ

1.1. Монгол Улсын Засгийн газар, түүний харъяа байгууллагууд, Төрийн захиргааны төв байгууллага яам, агентлагууд, Төрийн захиргааны байгууллага, түүний харъяа байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага - аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны засаг даргын тамгын газар, бусад төрийн үйлчилгээний байгууллагууд /цаашид “байгууллага” гэх/ (.gov.mn) домэйн нэрийг албан ёсны домэйн нэр болгон ашиглана.

1.2. Байгууллагад ашиглах домэйн нэр нь дараах түвшингүүдэд дугаарлана. Үүнд:

Нэгдүгээр түвшин	Хоёрдугаар түвшин	Гуравдугаар түвшин	Дөрөвдүгээр түвшин
Олон улсын ICANN байгууллагаас Монгол Улсад оноосон дээд түвшний домэйн нэр	Төрийн захиргааны байгууллагуудад олгох дээд домэйн нэр	Төрийн захиргааны байгууллагуудын эзэмших домэйн нэр	Нэгж харъяа байгууллагад оноосон дэд домэйн нэр
Загвар:			
.mn	.gov.mn	police.gov.mn	ub.police.gov.mn

- 1.3. Байгууллага нь салбар үйл ажиллагааны чиглэлээс хамааран бусад (org.mn, med.mn, mil.mn, edu.mn, aid.mn зэрэг) домэйн нэрийг давхар ашиглаж болно. Энэ нь тус журмаар үзүүлэх үйлчилгээнд хамаарахгүй.
- 1.4. Байгууллагын домэйн нэр нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг илэрхийлсэн үг, эсвэл байгууллагын монгол, англи нэрийн товчлол байж болно. Орон нутаг, бүсийн нэрийн товчлол, галигчлалд холбогдох стандартыг мөрдөнө. Харин байгууллагын өөрийн нэрийн орчуулга, товчлолыг тухайн байгууллагын хүсэлтийгүндэслэн шийдвэрлэнэ.
- 1.5. Цахим нэрийн хуваарилалт, оноолт, олголтыг Үндэсний Дата Төв УТҮГ-аас хариуцан 4.1, 4.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 1.6. Төрийн захиргааны төв байгууллага – яам, агентлагууд болон аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрууд гуравдугаар түвшний домэйн нэрийг ашиглах ба тэдгээрт шууд харъяалагдах захиргааны байгууллага нь дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг ашиглана.
- 1.7. Аль нэг Төрийн захиргааны төв байгууллага, яам, агентлагт харъяалагддаг хэдий ч улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь гуравдугаар түвшний домэйн нэрийг авч болно.

- 1.8. Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, түүний харъяа байгууллага, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, хөдөө орон нутагт байршилтай Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага нь орон нутгийн харъяаллыг тусгасан дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг авна. Тухайлбал: Замын-Үүд чөлөөт бүсийн зөвлөл www.freezezone.do.gov.mn;
- 1.9. Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага – орон нутаг болон нийслэлийн засаг захиргааны нэгжид харъяалагдах төрийн байгууллага нь удирдах дээд шатны байгууллагын домэйн нэрний дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг эсвэл орон нутаг, бүсийн нэрийн товчлол бүхий домэйн нэрийг авна. Тухайлбал: Нийслэлийн цагдаагийн газар www.police.ub.gov.mn;
- 1.10. Байгууллага нь төрийн цахим үйлчилгээ, салбар үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу домэйн нэрийг давхар авч болно. Тухайлбал: www.forecast.gov.mn, www.registration.gov.mn, www.tax.gov.mn, www.election.gov.mn, www.archive.gov.mn, www.immigration.gov.mn, www.weather.gov.mn гэх мэт.
- 1.11. Байгууллагын домэйн нэрийг Үндэсний Дата Төв УТҮГ-ын үйлчилгээний гэрээний үндсэн дээр олгоно.
- 1.12. Байгууллагын домэйн нэрийн тоонд хязгаарлалт тогтоохгүй бөгөөд gov.mn домэйн нэрийн дэд домэйн нэрийнгалбан хүсэлтийг үндэслэн үнэ төлбөргүйгээр олгоно.
- 1.13. Үндэсний Дата Төв УТҮГ нь домэйн нэрийг зөв ашиглах, аюулгүй байдлыг хангахад мэргэжлийн зөвлөгөө өгнө.
- 1.14. Домэйн нэрийг ашиглах гэрээний хугацаа дууссан, үйлчилгээний нөхцлийг ноцтой зөрчсөн тохиолдолд Үндэсний Дата Төв УТҮГ-аас домэйн нэрийн ашиглах эрхийг хүчингүй болгох, түр зогсоох хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 1.15. Байгууллага нь домэйн нэрийг ашиглах явцад техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, саатал гарсан нөхцөлд Үндэсний Дата Төв УТҮГ-т шуурхай хандаж холбогдох арга хэмжээг авч хамтран ажиллана.
- 1.16. Домэйн нэрийн систем, DNS болон бусад холбогдох техник, програм хангамжийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг Үндэсний Дата Төв УТҮГ хариуцан ажиллана.
- 1.17. Тухайн домэйн нэрээр хаяглагдсан аливаа цахим үйлчилгээ, сервисийг Үндэсний Дата Төв УТҮГ-ын үйлчилгээнд хамруулах эсвэл зөвхөн Монгол улсад байрлах аль нэг дэд бүтэц бүхий систем рүү холбосон байна.
- 1.18. Үндэсний Дата Төв УТҮГ-аас олгосон домэйн нэрийг өөрчлөх, шилжүүлэхэд хуучин нэрийн мэдээллийг 1 улирлын турш хадгалан зохих шилжүүлэлтийг дэмжиж ажиллана.

Хоёр. Цахим хуудас, цахим шуудан байршуулах үйлчилгээ

- 2.1. Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудас, Төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын албан хэрэгцээний цахим шууданг байршуулах үйлчилгээг 4.1, 4.2-т заасны дагуу, ҮДТ-ийн үйлчилгээний гэрээний үндсэн дээр үзүүлэх ба гэрээний загварыг Үндэсний Дата Төв УТҮГ-аас батална.
- 2.2. Төрийн байгууллагуудын зөвхөн албаны хэрэгцээний цахим шуудан, цахим хуудсыг интернетэд байршуулах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.
- 2.3. Үндэсний Дата Төв УТҮГ нь аюулгүй ажиллагааны хүрээнд Төрийн байгууллагуудад өөрийн цахим хуудсан дээр аюулгүй байдлын цоорхойг арилгах, засвар шинэчлэлтийг тогтмол хийх, цахим хуудас, цахим шууданг ажиллуулахтай холбоотой дүрэм журам, стандарт, бусад бодлогын бичиг баримтыг дагаж мөрдөхийг шаардаж болно.

Гурав. Сервер, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг зориулалтын серверийн өрөөнд байршуулах үйлчилгээ

- 3.1. Төрийн байгууллагуудад сервер тоног төхөөрөмж байршуулах үйлчилгээг 4.1, 4.3-т заасны дагуу үзүүлэх ба зөвхөн Төрийн албан хэрэгцээнд ашиглагдах сервер тоног төхөөрөмжийг үйлчилгээнд хамруулна.
- 3.2. Төрийн байгууллагын аливаа сервер тоног төхөөрөмж нь Үндэсний Дата Төв УТҮГ-ын үйлчилгээний нөхцөл, стандарт, шаардлагыг хангахгүй тохиолдолд байршуулахыг хориглоно.
- 3.3. Үндэсний Дата Төв УТҮГ-аас Төрийн байгууллагад гэрээний дагуу сервер тоног төхөөрөмж байршуулах үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дүрэм, журам бусад баримт бичгийг гаргаж, мөрдлөг болгон ажиллана.
- 3.4. Үндэсний Дата Төв УТҮГ нь өөрийн серверийн өрөөнд /зогсуурт/ байршуулсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн сүлжээ болон цахилгаан хангамжийн тасралтгүй ажиллагаа, орчны температур чийгшлийн тогтвортой байдлыг ханган ажиллана.
- 3.5. Үндэсний Дата Төв УТҮГ-ын серверийн өрөөнд байршиж буй Төрийн байгууллагын сервер, төхөөрөмжинд Монгол улсын холбогдох хуулиар хориглосон мэдээллийг байршуулахыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас бичгээр зөвшөөрөл авсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Дөрөв. Үйлчилгээний хязгаарлалт

- 4.1. Төрийн байгууллагад үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээнд тавигдах хязгаарлалтыг Төрийн байгууллагын ангилал, ажилтан албан хаагчийн тоонд харгалзуулан тогтоох ба түүнээс хэтэрсэн тохиолдолд тухайн байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэнэ.
- 4.2. Домэйн нэр олгох, цахим хуудас, цахим шуудан байршуулах үйлчилгээ

	Төрийн захиргааны төв байгууллага – ТЗТБ	ТЗТБ-ын харъяа байгууллагууд, Төрийн захиргааны байгууллага – ТЗБ	ТЗТБ, ТЗБ-ын харъяа байгууллага, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага
Домэйн нэр /загвар/	www.aaa.gov.mn	www.bbb.aaa.gov.mn	www.ccc.bbb.aaa.gov.mn
Цахим хуудас байршуулах дискийн багтаамж	10 GB	5 GB	1 GB
Цахим шуудан байршуулах дискийн багтаамж	20GB		
ҮНЭ ТӨЛБӨР	ҮНЭГҮЙ	ҮНЭГҮЙ	ҮНЭГҮЙ

- 4.3. Төрийн байгууллагын сервер, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг зориулалтын орчинд байршуулах үйлчилгээний хязгаарлалт

Төрийн байгууллагын ажилтан албан хаагчийн тоо	100 хүртэл	100-200	200-аас дээш
Байршуулах төхөөрөмжийн хэмжээ	2 unit хүртэл	4 unit хүртэл	8 unit хүртэл
Багцад хамаарах бусад боломжууд	Гадаад 1 Mbps, дотоод хязгааргүй урсгал.	Гадаад 1 Mbps, дотоод хязгааргүй урсгал.	Гадаад 1 Mbps, дотоод хязгааргүй урсгал.
ҮНЭ ТӨЛБӨР	ҮНЭГҮЙ	ҮНЭГҮЙ	ҮНЭГҮЙ